



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/214-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: ЦЭСБ-Аудит ХХК

Утас: 95112689 Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

## Товчилсон үгийн жагсаалт

---

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗГ	Засгийн газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН 1 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.БОЛОРМАА ТАНАА

2023.02.25 № 037/2023/214-НА-СТА-ТЧЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 91.1 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон НДШ-ийн зардал тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, батлагдсан төсвийг 8.9 хувиар хэмнэсэн байна.

### Аудитын гол асуудал

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, бараа үйлчилгээний зардлын 75,9 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 7,7 хувийг байр ашиглалттай холбоотой

018020276

тогтмол зардал, 7,2 хувийг нормативт зардал буюу хүүхдийн хоолны зардал тус тус эзэлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

□□□□□□ □□□	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,558,178.22</b>	<b>73,603,925.11</b>
31	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	-	<b>33,876,433.89</b>
311	Кассанд байгаа		
312	Банкинд байгаа		
33	<b>АВЛАГА</b>	<b>54,423.72</b>	<b>54,423.72</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
335	Бусад авлага	54,423.72	54,423.72
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>30,503,754.50</b>	<b>39,673,067.50</b>
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал	-	-
354	<b>Хангамжийн материал</b>	<b>30,503,754.50</b>	<b>39,673,067.50</b>
35410	Бичиг хэргийн материал	-	155,000.00
35420	Аж ахуйн материал	20,608,648.50	25,877,691.50
35460	Хүнсний материал	710,946.00	1,654,066.00
35470	Бусад хангамжийн материал	9,184,160.00	11,986,310.00
356	<b>Мал амьтад</b>	-	-
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>		
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>325,255,900.34</b>	<b>313,726,108.00</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>325,255,900.34</b>	<b>313,726,108.00</b>
392	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>314,751,900.34</b>	<b>303,222,108.00</b>
39201	Барилга байгууламж	273,357,400.00	273,357,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,580,847.28)	(28,774,463.04)
39205	Машин тоног төхөөрөмж	52,120,200.00	53,580,650.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,393,909.37)	(32,396,723.56)
39207	Тавилга, эд хогшил	12,871,226.28	18,727,196.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,247,900.81)	(8,587,542.35)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,477,900.00	6,477,900.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,086,893.00	38,086,893.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,702,877.48)	(17,634,453.33)
39217	Ном	763,816.00	385,251.00
393	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>10,504,000.00</b>	<b>10,504,000.00</b>
39301	Программ хангамж	-	-
39302	Хасагдуулга	-	-
39303	Бусад биет бус хөрөнгө	10,504,000.00	10,504,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>355,814,078.56</b>	<b>387,330,033.11</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,075,720.80</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,075,720.80</b>
41361	Байгууллагад төлөх өглөг		1,075,720.80
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>355,814,078.56</b>	<b>386,254,312.31</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	355,814,078.56	386,254,312.31
511	Засгийн газрын оруулсан капитал	72,194,770.87	72,194,770.87
51101	Өмч: -төрийн	-	-
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>7,301,684.12</b>	<b>37,741,917.87</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	10,923,999.96	(349,745,019.81)
51220	Тайлант үеийн үр дүн	(3,622,315.84)	387,486,937.68
51300	Дахин үнэлгээний зөрүү	276,317,623.57	276,317,623.57
6	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>355,814,078.56</b>	<b>387,330,033.11</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>327,973,456.90</b>	<b>753,197,863.47</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,948,766.00</b>	<b>373,581,131.50</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>11,948,766.00</b>	<b>373,581,131.50</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,948,766.00	373,581,131.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	373,581,131.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,565,620.00	335,931,884.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,383,146.00	37,649,247.00
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>316,024,690.90</b>	<b>379,616,731.97</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>291,728,300.00</b>	<b>325,975,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,728,300.00	325,975,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>942,172.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	291,728,300.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,354,218.90</b>	<b>53,641,231.97</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,354,218.90	53,641,231.97
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>331,595,772.74</b>	<b>365,240,717.68</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>331,595,772.74</b>	<b>365,240,717.68</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>315,092,083.39</b>	<b>365,240,717.68</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>223,324,181.00</b>	<b>246,431,474.07</b>
210101	Үндсэн цалин	151,187,652.00	188,674,988.07
210102	Нэмэгдэл цалин	56,138,982.00	47,304,875.00
210104	Урамшуулал	15,997,547.00	10,451,611.00
2102	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>28,924,907.93</b>	<b>31,021,751.10</b>
210201	Тэтгэврийн даатгалын	20,264,365.73	21,908,581.82
210202	тэтгэмжийн даатгалын	2,235,389.94	2,452,180.07
210203	ҮОМШӨ-ий даатгалын	1,814,495.42	1,897,903.98
210204	Ажилгүйдлийн даатгалын	388,386.66	463,246.76
210205	ЭМ-ийн даатгалын	4,222,270.18	4,299,838.47
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,252,618.90</b>	<b>28,072,608.71</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	2,417,418.90	4,246,752.36
210302	Түлш, халаалтын зардал	16,835,200.00	20,322,424.35
210303	Цэвэр бохир усны зардал	1,000,000.00	3,503,432.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,778,491.00</b>	<b>2,823,770.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	1,037,200.00	2,394,820.00
210404	Тээвэр шатахуун	176,400.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	932,200.00	
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	542,100.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	1,499,091.00	113,950.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	591,500.00	
210408	Бараа материал акталсны зардал	-	315,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>10,418,714.00</b>	<b>26,343,715.00</b>
210502	Хоол, хүнс	9,111,814.00	26,311,165.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	338,000.00	32,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	968,900.00	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,568,499.99</b>	<b>5,510,199.90</b>
210601	Багаж техник, хэрэгсэл	87,499.99	874,999.90

210604	Урсгал засварын зардал	3,481,000.00	4,635,200.00
<b>2107</b>	<b>Томилолтын зардал</b>	<b>60,200.00</b>	<b>192,000.00</b>
210702	Дотоодын томилолт	60,200.00	192,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>996,755.00</b>	<b>262,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	348,755.00	
210802	Аудит баталгаажуулалтын зардал	648,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		262,500.00
<b>2109</b>	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,767,715.57</b>	<b>24,582,698.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,298,880.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	525,700.00	652,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,242,015.57	19,631,018.90
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>16,503,689.35</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,503,689.35	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(3,622,315.84)</b>	<b>387,957,145.79</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>		
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>470,208.11</b>
225001	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө		470,208.11
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал		
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>	-	(470,208.11)
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(3,622,315.84)</b>	<b>387,486,937.68</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>316,024,690.90</b>	<b>379,616,731.97</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>316,024,690.90</b>	<b>379,616,731.97</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>291,728,300.00</b>	<b>325,975,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,728,300.00	325,975,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>942,172.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	942,172.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,354,218.90</b>	<b>53,641,231.97</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,354,218.90	53,641,231.97
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>306,901,290.90</b>	<b>345,740,298.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>306,901,290.90</b>	<b>345,740,298.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>290,397,601.55</b>	<b>345,740,298.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>223,324,170.00</b>	<b>244,952,010.87</b>
210101	Үндсэн цалин	150,860,104.00	189,694,703.87
210102	Нэмэгдэл	56,466,519.00	44,805,696.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	15,997,547.00	10,451,611.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,979,342.65</b>	<b>31,420,493.50</b>
210201	Тэтгэврийн даатгалын	20,252,383.52	21,908,581.82
210202	Тэтгэмжийн даатгалын	2,250,276.81	2,465,951.69
210203	ҮОМШӨ-ий даатгалын	1,792,775.60	1,897,903.98
210204	Ажилгүйдлийн даатгалын	437,698.74	507,081.11
210205	Эрүүл мэндийн даатгалын	4,246,207.98	4,640,974.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,252,618.90</b>	<b>28,072,608.71</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	2,417,418.90	4,246,752.36
210302	Түлш, халаалтын зардал	16,835,200.00	20,322,424.35
210303	Цэвэр бохир усны зардал	1,000,000.00	3,503,432.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	<b>1,882,400.00</b>	<b>-</b>
210401	Бичиг хэргийн зардал	78,000.00	
210404	Тээвэр шатахуун	176,400.00	
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	932,200.00	
210404	Ном	33,300.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	522,100.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	140,400.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,126,270.00</b>	<b>27,261,785.00</b>
210501	Эм	49,700.00	
210502	Хоол, хүнс	9,553,070.00	27,261,785.00
210503	Нормын хувцас	523,500.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>3,481,000.00</b>	<b>4,635,200.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	-	-
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210604	Урсгал засвар	3,481,000.00	4,635,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>60,200.00</b>	<b>-</b>
210702	Дотоодын томилолт	60,200.00	

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>948,000.00</b>	<b>427,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		427,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,343,600.00</b>	<b>8,970,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,720,700.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,343,600.00	2,250,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,503,689.35</b>	<b>-</b>
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>2133</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт</b>	<b>16,503,689.35</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,503,689.35	
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2220</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>-</b>
222001	Тоног төхөөрөмж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
225107	Тоног төхөөрөмж		
225108	Бусад хөрөнгө		
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>9,123,400.00</b>	<b>33,876,433.89</b>
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<b>4</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>		
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>9,123,400.00</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>9,123,400.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,123,400.00</b>	<b>-</b>
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	(9,123,400.00)	-
222001	Тоног төхөөрөмж	-	-
223001	Бусад хөрөнгө	9,123,400.00	-
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(9,123,400.00)</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(0.00)</b>	<b>33,876,433.89</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>33,876,433.89</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
<b>2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,194,770.87</b>	<b>276,317,623.57</b>	<b>10,923,999.96</b>	<b>359,436,394.40</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(3,622,315.84)	<b>(3,622,315.84)</b>
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,194,770.87</b>	<b>276,317,623.57</b>	<b>7,301,684.12</b>	<b>355,814,078.56</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт			(357,046,703.93)	<b>(357,046,703.93)</b>
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			387,486,937.68	<b>387,486,937.68</b>
<b>2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,194,770.87</b>	<b>276,317,623.57</b>	<b>37,741,917.87</b>	<b>386,254,312.31</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	379,616,731.97	345,740,298.08	33,876,433.89	91.1
21	Урсгал зардлын дүн	379,616,731.97	345,740,298.08	33,876,433.89	91.1
210	Бараа үйлчилгээний зардал	379,616,731.97	345,740,298.08	33,876,433.89	91.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	275,343,300.00	244,952,010.87	30,391,289.13	89.0
210101	Үндсэн цалин	213,977,000.00	189,694,703.87	24,282,296.13	88.7
210102	Нэмэгдэл	56,768,600.00	44,805,696.00	11,962,904.00	78.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	
210104	Урамшуулал	4,597,700.00	10,451,611.00	(5,853,911.00)	227.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,575,223.26	31,420,493.50	2,154,729.76	93.6
210201	Тэтгэврийн даатгал	23,028,400.00	21,908,581.82	1,119,818.18	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,642,500.00	2,465,951.69	176,548.31	93.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,096,100.00	1,897,903.98	198,196.02	90.5
210204	Ажилгүйдлийн даатгал	567,823.26	507,081.11	60,742.15	89.3
210205	ЭМД-ын хураамж+B21	5,240,400.00	4,640,974.90	599,425.10	88.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,072,608.71	28,072,608.71	-	100.0
210301	Гэрэл цахилгааны зардал	4,246,752.36	4,246,752.36	-	0.0
210302	Түлш, халаалтын зардал	20,322,424.35	20,322,424.35	-	0.0
210303	Цэвэр бохир усны зардал	3,503,432.00	3,503,432.00	-	0.0
2105	Нормативт зардал	28,427,700.00	27,261,785.00	1,165,915.00	95.9
210501	Эм	-	-	-	0.0
210502	Хоол хүнс	28,427,700.00	27,261,785.00		95.9
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,635,200.00	4,635,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	4,635,200.00	4,635,200.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	592,000.00	427,500.00	164,500.00	72.2
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	592,000.00	427,500.00	164,500.00	72.2
210807	Газрын төлбөр			-	
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			-	

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх			-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,970,700.00	8,970,700.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,720,700.00	6,720,700.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,250,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал			-	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	325,975,500.00	325,975,500.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	379,616,731.97	379,616,731.97	-	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	325,975,500.00	325,975,500.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих			-	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			-	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	53,641,231.97	53,641,231.97	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	53,641,231.97	53,641,231.97	-	0.00
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		33,876,433.89	(33,876,433.89)	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	20.00	2.00	90.9
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	8.00	9.00	(1.00)	112.5
	Үйлчлэх ажилтан	13.00	10.00	3.00	76.9
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/	97.00	97.00	-	100.0
015	Төрийн өмчит СӨБ байгууллага	97.00	97.00	-	100.0
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	22.00	-	100.0
028	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	22.00	22.00	-	100.0
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	-	-	-	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн сурах тэгш боломжийг бүрдүүлж, багшийн хөгжлийг дэмжин ажиллана.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл аюулгүй тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх,
- Сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлд суурилан тасралтгүй хөгжих олон хэлбэрт үйл ажиллагаанд хамрагдах,
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж төсвийг төлөвлөх, үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай ажиллах,
- Багш нар технологийн дэвшлийг ашиглан орон зайнаас үл хамааран ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэн бүтээлчээр ашиглах,
- Мэргэжлийн хөгжлийн бүлэгтээ хамтран ажиллах зөвлөх, тэргүүлэх багшийн манлайлал үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах

- багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
  - ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан. Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,516.0 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		33,876.4	33,876.4
Авлага	54.4	54.4	-
Бараа материал	30,503.7	39,673.1	9,169.4
Үндсэн хөрөнгө	325,255.9	313,726.1	(11,529.8)
Нийт хөрөнгө	<b>355,814.0</b>	<b>387,330.0</b>	<b>31,516.0</b>
Өр төлбөр	-	1,075.7	1,075.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	355,814.0	386,254.3	30,440.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>355,814.0</b>	<b>387,330.0</b>	<b>31,516.0</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 33,876.4 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,673.1 мянган төгрөг болж 9,169.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 43,829.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 391.5 мянган төгрөгийн аж ахуйн материал хүлээн авч орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 35,052.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 401,119.3 мянган төгрөг болж 4,812.3 мянган төгрөгөөр буурсан нь Шаамар сумын хөрөнгө оруулалтаар 6,000.0 мянган төгрөгийн /ятга, бөмбөр, юочин, шанз, морин хуур/ тавилга эд хогшил, БШУЯ-наас 3,100.0 мянган төгрөгийн /1-р хоолны тогоо/, 220,0 мянган төгрөгийн /кварц гэрэл/ машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд сумын ИТХ-ийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор 3,700.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 379.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 428.5 мянган төгрөгийн номыг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 386,254.3 мянган төгрөг болж 30,440.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 424,215.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 60,680.2 мянган төгрөгөөр нийт зарлагыг 484,896.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд хийсэн төсвийн зохицуулалтаар цалин, НДШ-ийн зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас нийт 105,279.4 мянган төгрөгөөр бууруулан нийт төсвийг 379,616.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 325,975.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 53,641.2 мянган төгрөг нийт 379,616.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 345,740.3 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 30,391.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,154.7 мянган төгрөг, нормативт зардал буюу хүүхдийн хоолны зардлаас 1,165.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр 164.5 мянган төгрөгийг тус тус хэмнэн 33,876.4 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	800.0	800.0	0	100
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	28,427.7	27,261.8	1,165.9	95.9
		3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	668.7	668.7	0	100
		4	81823- Боловсролын байгууллагын багш	800.0	800.0	0	100
		5	81834- Боловсролын стандарт, сургалтын	230,213.5	211,193.9	19,019.6	87.36
		6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	65,065.6	51,374.7	13,690.9	78.96
			80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	32,707.8	32,707.8	0	100
			80112- Нийтлэг үйлчилгээ	20,933.4	20,933.4	0	100

	<b>Нийт</b>	379,616.7	345,740.3	33,876.4	89.61
--	-------------	-----------	-----------	----------	-------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 331,595.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,315.9

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, цэцэрлэгийн хүүхдийн хоол зэрэг нийт 33,876.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“ЦЭСБ-Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 21-ний 212 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 3,160.2 мянган төгрөгийн, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	192.9	1	192.9	100.0
Зөвлөмж	1	3,160.2			55
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>3,353.1</b>	<b>2</b>	<b>3,353.1</b>	<b>77.5</b>

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудал нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг

санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.

3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

#### 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүү байдлын тайлангийн бараа материалыг 3,503.7 мянган төгрөг, авлагыг 54.4 мянган төгрөг зэрэг нийт 3,558.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

Аудитаар нийт 3,086.5 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илрүүлснээс, **3,086.5** мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

##### 5.1 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс **2,010.8** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

2. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **1,075.7** мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг шинээр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянасны үндсэн дээр өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Зөвлөмж

### 1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

**1.1** Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна.”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүү байдлын эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлсэн	1	3,558.1					1	3,558.1				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,558.1</b>					<b>1</b>	<b>3,558.1</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахим төлбөрийн баримтаар баталгаажуу лаагүй	1	2,010.8			1	2,010.8						
Өглөг үүсгэсэн	1	1,075.7			1	1,075.7						
Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1						1					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,086.5</b>			<b>2</b>	<b>3,086.5</b>	<b>1</b>	<b>-</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
							-	
Дүн							-	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								